

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

(2022 оны жилийн эцсийн байдлаар)

2022.11.23

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлогын 5 тэргүүлэх зорилтод хамаарах нийт 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 36 хавсралт (ЗГ-ын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)-д заасан загвар хүснэгтээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнав.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг хавсралт – 1, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг хавсралт 2-оор тайлагнав.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

Бодлого, арга хэмжээгээр харуулбал:

- Эдийн засгийн бодлогын 2 зорилтын 3 арга хэмжээний дундаж 43.3 хувь;
- Засаглалын бодлогын 3 зорилтын 9 арга хэмжээний дундаж 94.4 хувь.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилтот түвшингийн 2022 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаарх хэрэгжилт– 81.7% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Бодлого	
			Эдийн засаг	Засаглал
1	Хяналтад авсан зорилтын тоо	5	2	3
2	Хяналтад авсан арга хэмжээний	12	3	9

	тоо				
3	Үнэлгээний хувь	100.0 хувь	3	-	3
4		90.0 хувь	6	-	6
5		70.0 хувь	1	1	-
6		50.0 хувь	-	-	-
7		30.0 хувь	2	2	-
8		0.0 хувь	-	-	-
9	Хэрэгжилтийн хувь		81.7 хувь	43.3 хувь	94.4 хувь


Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:

- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 2 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 62.0 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувь;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь;
- Хууль, эрх зүйн хэлтэс (ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ) 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Хэлтэс				
			ТӨУЗХэлтэс	ТӨБАХэлтэс /МТА, ЗУХ/	ТӨХШХэлтэс	ХЭЗХэлтэс /ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ/	
1	Хяналтад авсан арга хэмжээний тоо	12	5	2	2	3	
2	Үнэлгээний хувь	100.0 хувь	3	-	1	2	-
3		90.0 хувь	6	2	1	-	3
4		70.0 хувь	1	1	-	-	-
5		50.0 хувь	-	-	-	-	-
6		30.0 хувь	2	2	-	-	-
7		0.0 хувь	-	-	-	-	-
8	Хэрэгжилтийн хувь	81.7 хувь	62.0 хувь	95.0 хувь	100.0 хувь	90.0 хувь	

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021 он, 2022 оноор харьцуулбал:

ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ



Гурав. Дүгнэлт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021 онтой харьцуулахад хэрэгжилтийн

үнэлгээний хувь 10-аар буурсан шалтгааныг авч үзвэл 3.2.7.5, 3.2.7.6 дугаар арга хэмжээг тавьсан зорилтод хүрэх зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч, ковид 19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжилт төлөвлөсөн цаг хугацаанаас хойшлогдсон ялангуяа цаг хугацаа шаардсан бүтээн байгуулалтын ажлууд, 3.7.8.1 дүгээр арга хэмжээ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шууд хамаарах ажлыг гүйцэтгэсэн ч, хамтран хэрэгжүүлэгч байгууллагаас хамаарч үр дүн гарахтай холбоотой байна.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр цахимаар тухайн зорилт, арга хэмжээний хүрээнд гарсан үр дүнг тайлагнаж байгаатай холбогдуулан бодит үр дүнг нэмэгдүүлэхэд санал санаачилга гаргаж ажиллах;
- Тайлант үеийн мэдээллээ ирүүлэлгүй өмнөх биелэлтийг хуулж тавьсан, бодит үнэлгээ өгөлгүй үнэлгээг хэт өсгөсөн тохиолдолд удирдлага, дээд шатны байгууллагад худлаа, зөрүүтэй мэдээлэл өгсөн гэж үзэн холбогдох албан тушаалтанд журмын дагуу хариуцлага тооцон арга хэмжээ авч байхыг ЗГХЭГ-аас мэдэгдсэнийг бүх хэлтэс, албаны дарга нар, холбогдох мэргэжилтнүүд анхаарч ажиллах;
- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарсан санхүүжилтийг өссөн дүнгээр тайлагнаж байх;
- Хэрэгжилтэд тодорхой үр дүн гараагүй шийдвэрүүдийг зохион байгуулалтын арга хэмжээ авч, эрчимжүүлэх;

Шийдвэрлүүлэх асуудал /Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд/

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний:

- “4.1.4.5. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно” гэсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбох арга хэмжээ нь ТӨБЗГазарт хамаарах заалт биш учраас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn–нээс хасалт хийлгүүлэх саналтай байна.


Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН  Д.ЦЭРЭНЛХАМ